

СУРГАЛТЫН АГУУЛГЫН ХУРААНГУЙ

1. Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын тухай ойлголт

Багш: Б.Болороо

Хугацаа: 60 минут

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн, хөгжлийн бэрхшээлийн сургагч багш

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Хөгжлийн бэрхшээлийн чиг хандлага
2. Хөгжлийн бэрхшээлийн талаарх загвар, ойлголтууд
3. Уламжлалт хандлагын үзүүлэх нөлөөг ярилцах
4. Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлийн салбарын хөгжил (конвенц, хууль эрх зүйн нөлөөг оролцуулан)

Уншиж, судлах материал:

- (1) Илтгэлүүд;
- (2) Видео: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих/АХБ, Ядуурлыг бууруулах Японы сан 2021;
- (3) "Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийн тайлан. 2020;
- (4) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (5) хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ийн конвенц

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв: үйлчилгээний тухай танилцуулга

Багш: А. Балжинням¹ / Шэйла Пүрвэс²

Хугацаа: 60 минут

¹Дэд профессор, Сэргээн засах анагаах ухааны тэнхим, АШУУИС, ХНХЯ/АХБ төслийн С2 зөвлөх

² Хонг Конгийн сэргээн засахын нийгэмлэгийн зөвлөх, ХНХЯ/АХБ төслийн С2 зөвлөх

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Хөгжлийн төвүүдийн ерөнхий зорилго, стратеги, бүтэц
2. Орон нутгийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахын ач холбогдол
3. ХТ-ийн мэргэжилтнүүдэд тулгарах бэрхшээл, сургагч багш нарын дэмжлэг, түүний үүргийн тухай
4. Өдөр тутмын ажилд тулгарч буй бэрхшээлийг даван туулахад багаар ажиллахын ач холбогдол, багийн үйл ажиллагааг сайжруулах арга замууд

Уншиж, судлах материал:

- (1) илтгэлүүд;
- (2) Видео: Сөүл хотын нийгмийн сэргээн засах төв: насанд хүрэгчдийг "энгийн амьдралд" хүргэх (2019)

3. Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF) (Эхний хэсэг)

Багш: Шэйла Пүрвэс (А.Балжинням орчуулна)

Хугацаа: 60 минут

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Олон мэргэжлийн багийн гишүүдийн үүрэг
 2. Багийн үйл ажиллагааг сайжруулах арга замууд
- Даалгавар #1: ICF-ийн хүрээг ашиглан үйлчлүүлэгчтэй ярилцлага хийх (сургалтын материал)

Уншиж, судлах материал:

- (1) илтгэлүүд;
- (2) Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын: Танилцуулга

4. Багийн зорилгыг тодорхойлж, цогц төлөвлөгөө хийх

Багш: Шэйла Пүрвэс (А.Балжинням орчуулна)

Хугацаа: 60 минут

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. ICF-ийн хүрээнд үйлчлүүлэгчийн нөхцөл байдалд дүгнэлт хийх
2. Биеийн гэмтэл, үйл ажиллагаа, оролцоо болон орчны байдалд тохируулан зорилго тодорхойлох дадлага хийх
3. Нэн тэргүүнд шаардлагатай үйлчилгээ, үр дүнг хэмжих
4. Багийн гишүүдийн хүлээх хариуцлага (үйлчлүүлэгч, гэр бүл, орон нутгийн байгууллагуудыг оролцуулан)

Даалгавар #2: Үйлчлүүлэгчийн зорилго, үүрэг хариуцлагыг тодорхойлох (сургалтын материал)

5. ICF-ийн хүүхэд, залуучуудын үнэлгээ; үндсэн багц, WHODAS2, CASP

Багш: Шэйла Пүрвэс / А.Балжинням

Хугацаа: 60 минут

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. ДЭМБ, ICF-хүүхэд, залуучуудын үнэлгээ, түүний хэрэглээ
2. Сэргээн засахын цогц төлөвлөгөө гаргах, багийн үйл ажиллагааг сайжруулахад ICF-ийн үндсэн багцын ач холбогдол
3. Хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог үнэлэх аргын хэрэглээ, ач холбогдол (CASP)
4. ДЭМБ-хөгжлийн бэрхшээлийг үнэлэх аргын хэрэглээ, ач холбогдол (WHO DAS2)
5. Үйл ажиллагаа, оролцооны түвшнийг сайжруулахад амжилтыг тооцох, түүний үр дүнг хэрэглэхийн ач холбогдол, дээрх аргуудыг ашиглан дадлага хийх

Уншиж, судлах материал:

- (1) илтгэлүүд;
- (2) WHO DAS2-36 Монгол хэл дээрх хувилбар
- (3) CASP Монгол хэл дээрх хувилбар

Даалгавар #3: WHO DAS2 (насанд хүрэгчид) эсвэл CASP (хүүхэд эсвэл эцэг эх) - ийн хувилбарыг ашиглан асуултад хариулах (сургалтын материал)

6. Давуу талд тулгуурлах хандлага болон кейс менежмент

Багш: М.Нямдорж

Хугацаа: 120 минут

МУБИС, Нийгмийн ажил аргазүйн тэнхим, ахлах багш

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Давуу талд тулгуурлах хандлагыг өөрийн мэргэжил, кейс менежменттэй уялдуулах
2. Хөгжлийн бэрхшээл болон сэргээн засахын салбарын кейс менежментийн зорилгыг тайлбарлах
3. Сэргээн засахын кейс менежментийн явцын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох

Уншиж, судлах материал:

- (1) илтгэл

Даалгавар #4: хүүхэд, насанд хүрэгчдийн кейс дээр давуу тал, тусламж үйлчилгээ, лавлагаа төвүүдийг тодорхойлох (сургалтын материал)

7. Эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцооны тогтолцоо ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын (ХБХЭМБНХСК) үүрэг

Багш: Г.Соёлгэрэл

Хугацаа: 60 минут

ХНХЯ/АХБ төслийн С2 зөвлөх

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Эрт илрүүлэлт, хөгжлийн дэмжлэг оролцооны ач холбогдол
2. Хөгжлийн бэрхшээл эсвэл хөгжлийн хоцрогдолтой нь тодорхойлогдсон хүүхдийн тусламж үйлчилгээ авах урсгал
3. Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үндсэн үүрэг

Уншиж, судлах материал:

- (1) илтгэл;
- (2) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, 2018;
- (3) Бага насны хүүхдийн цогц хөгжил. НҮБ-ийн хүүхдийн сан, 2020;
- (4) Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл. ДЭМБ, НҮБ-ийн хүүхдийн сан 2012.

8. Сургуулийн өмнөх насанд эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцоо, эцэг эхчүүдэд үзүүлэх дэмжлэг (Хонг Конг)

Багш: Нанси Цанг

Хугацаа: 90 минут

Гүйцэтгэх захирал (асан), Хийп Хонг Нийгэмлэг, Хонг Конг

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Сургуулийн өмнөх насанд хөгжлийн дэмжлэг оролцооны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох, Хонг Конгийн туршлага
2. Сургуулийн өмнөх насны хүүхдийг сургуульд бэлтгэх олон мэргэжлийн багийн гишүүдийн үүргийн талаар хэлэлцэх

Уншиж, судлах материал:

- (1) илтгэл;
- (2) Видео: Сургуулийн өмнөх сэргээн засах үйлчилгээ;
- (3) илтгэлийн бичлэг (англи, монгол хэл дээр)

9. Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш хамруулах боловсрол

Багш: Б.Гэрэлтуяа

Хугацаа: 90 минут

БШУЯ-ны тусгай хэрэгцээт боловсролын ахлах мэргэжилтэн

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Монгол улс дахь хүртээмжтэй боловсролын өнөөгийн явц, ахиц дэвшил
2. Сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон бусад хүүхэд, багш нар, сургуульд үзүүлэх шаардлагатай дэмжлэг
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэхэд сэргээн засах багийн гишүүдийн гүйцэтгэх үүрэг, дэмжлэгийн талаар эргэцүүлэн бодох

Уншиж, судлах материал:

- (1) илтгэл;
- (2) Монголын улсын хууль, дүрэм журам

Эргэцүүлэл #1: Үйлчлүүлэгчийн боловсрол эзэмшихэд үзүүлэх дэмжлэгийн талаарх асуултад хариулах (сургалтын материал)

10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах тухай

Багш: Ч.Ундрахбаяр

Хугацаа: 120 минут

Түгээмэл хөгжил ТББ-ын тэргүүн, Бие даан амьдрах төвийг үүсгэн байгуулагч

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Бие даан амьдрах үзэл баримтлал, зарчим, Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, зөвлөлдөх бүлгийн зөвлөх, хувийн туслах болон бусад хүмүүсийн үүргийн тухай
3. Давуу талд тулгуурласан хандлагаар дамжуулан бие даан амьдрах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийгмийн ажилтан, хөдөлмөр сургалтын мэргэжилтэн, хөдөлгөөн засалч, туслах технологийн техникч нарын гүйцэтгэх үүрэг
4. Бие даан амьдрах зорилгод хүрэхэд чиглэсэн бодлого, төрийн үйлчилгээ (эрүүл мэнд, сэргээн засах үйлчилгээ орно), гэр бүл, нийгмийн хандлагын нөлөө

Уншиж, судлах материал:

- (1) илтгэл;
- (2) Бие даан амьдрах эрх судалгаа. Түгээмэл хөгжил төв;
- (3) Хөгжлийн бэрхшээлтэй хүний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал 2020.

11. Хөдөлмөрийн сэргээн засах

Багш: Чибан Х.¹ / Насандэлгэр²

Хугацаа: 120 минут

¹ЖАЙКА, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн ерөнхий зөвлөх, 2021 оноос; (ХНХЯ/АХБ төслийн зөвлөх С4 2020 – 06/21)

² ХНХЯ/АХБ төслийн зөвлөх С4 2020 – 10/21

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Хөдөлмөрийн сэргээн засахын одоогийн байдал, ач холбогдол,
2. Хөдөлмөр эрхлэх боломж, шаардлагатай дэмжлэг
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьжиргааг сайжруулах олон төрлийн боломжууд, Монгол Улсын баримталж буй бодлогын талаар

Уншиж, судлах материал:

- (1) илтгэл;
- (2) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, 2018;
- (3) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. Дүгнэлт-РРТ 2018.

Эргэцүүлэл #2: хөдөлмөр эрхлэлтийн асуудлуудыг оролцуулан бие даан амьдрахыг дэмжихтэй холбоотой асуултад хариулах (сургалтын материал)

12. Оюуны бэрхшээлтэй залуусыг насанд хүрэх шилжилтийн үед нь дэмжлэг үзүүлэх: Тохиолдлын судалгаа

Багш: К.Сунг

Хугацаа: 120 минут

Дэд профессор, боловсролын сэтгэл судлал ба тусгай хэрэгцээт боловсролын тэнхим, Мичиганы их сургууль, АНУ

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Өсвөр наснаас насанд хүрэхэд шилжих үе шатыг төлөвлөх ач холбогдол
2. Харилцааны чадварыг сайжруулах, ажлын байранд дадлагажих, туршлагаар дамжуулан хөгжүүлэхийн ач холбогдол
3. Ажилд зуучлахад орон нутгийн байгууллага, ажил олгогчтой хамтран идэвхтэй ажиллах ач холбогдол
4. Өсвөр насны, залуучуудтай ажилладаг олон мэргэжлийн багийн гишүүдийн үүргийг тодорхойлох

Уншиж, судлах материал:

- (1) илтгэл;
- (2) Илтгэлийн бичлэг (Англи/Монгол хэл дээр)

13. Туслах технологийн тухай

Багш: С.Дийпак¹, Д.Тулгамаа²

Хугацаа: 120 минут

¹ Сургагч, Хөгжлийн бэрхшээлийн судлаач; ХНХЯ/АХБ төслийн зөвлөх

² AIFO Монгол дахь зохицуулагч; ХНХЯ/АХБ төслийн зөвлөх

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Туслах технологийн өөрчлөлт, шинэчлэлт
2. Монгол Улсын туслах технологийн тогтолцооны тухай, хийгдэж буй шинэчлэлт

Уншиж, судлах материал:

(1) илтгэл;

(2) ДЭМБ, туслах бүтээгдэхүүний жагсаалт 2016, Англи хэл дээр;

(3) ДЭМБ, туслах бүтээгдэхүүний жагсаалт, Монгол хэл дээр;

(4) Олон улс дахь туслах технологийн өнөөгийн байдал

(5) ДЭМБ Видео: туслах бүтээгдэхүүний үйлчилгээний хангамжийн талаарх танилцуулга

Даалгавар #5: Гурван өөр үйлчлүүлэгчийн хэрэглэж болох туслах бүтээгдэхүүний жагсаалт (сургалтын материал)

14. Жендерийн мэдрэг байдал

Багш: Б.Чулуундолгор

Хугацаа: 60 минут

Монголын тэргэнцэртэй иргэдийн холбоо, тэргүүн

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Монгол Улсын жендерийн тэгш байдлыг хангах эрх зүйн үндэс
2. Ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүчирхийлэлд хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өртөх эрсдэл
3. Хөгжлийн бэрхшээл болон эмэгтэй хүйсийн улмаас хүчирхийлэлд болон ядууралд өртөх эрсдэл
4. Эерэг хандлагыг загварчлах, эрсдэлтэй хүүхэд, насанд хүрэгчдийг тодорхойлоход нийгмийн, сэргээн засахын, эрүүл мэндийн ажилтны хувьд өөрсдийн хүлээх хариуцлагын тухай эргэцүүлэн бодох

Уншиж, судлах материал:

(1) илтгэл;

(2) Хөгжлийн бэрхшээлтэй хүн хүчирхийлэлд өртсөн эсэхийг үнэлэх хуудас;

(3) Дарамт, хүчирхийлэл, өөрийгөө хамгаалах (хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн гарын авлагаас)

(4) Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх, 2018

Эргэцүүлэл # 3: Үйлчлүүлэгчийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг шалгах хуудас (АНУ), Монгол ахуйд тохирох эсэхийг авч үзэх (Монгол орчуулгын төсөл/асуулт, сургалтын материал)

15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд заах арга

Багш: М.Мөнхшүр

Хугацаа: 60 минут

ХНХЯ/АХБ төслийн С2 зөвлөх ,

Сургалтын зорилго: Суралцагч сургалтын төгсгөлд дараах зүйлсийг сурсан байна:

1. Эрт үеийн хөгжлийн дэмжлэг оролцооны зорилго, ач холбогдол
2. Эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцоог хэрэгжүүлэх арга (үнэлгээ хийх⇒зорилт дэвшүүлэх⇒төлөвлөгөө боловсруулах⇒дэмжлэг үзүүлэх)-д суралцах
3. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүний эцэг эх, асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлж, оролцоог нэмэгдүүлэн, гэртээ хүүхдээ хөгжүүлэх чадварыг дээшлүүлэх талаар сурч мэдэх
4. Эрт үеийн хөгжлийн дэмжлэг оролцооны үйлчилгээний эцэг эх/асран хамгаалагч, мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааны ач холбогдлыг ойлгоно.

Уншиж, судлах материал: (1) илтгэл

